



155

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 19 өдөр


Дугаар A/139

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтооолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/112 дугаар тушаалын хавсралт дахь Чилхаасүрэн овогтой Батсуурьд холбогдох хэсгийн “AHU, California State University” гэснийг “Австрали, La Trobe University” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/221 дугаар тушаалын хавсралт дахь Эрдэнэбилэг овогтой Ануунгоод холбогдох хэсгийн “University of Canada West, төслийн менежмент” гэснийг “BNSU, Kookmin University, олон улсын бизнес” гэж, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын “Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2016 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/09 дугаар тушаалын хавсралт дахь Баатарчулуун овогтой Сонинхүүд холбогдох хэсгийн “IGlobal University, Бизнесийн удирдлага” гэснийг “Австри, University of Vienna, электроник” гэж, Баатарсуурь овогтой Оюунчимэгт холбогдох хэсгийн “Virginia International University, төрийн удирдлага” гэснийг “Western Sydney University, нийгмийн шинжлэх ухаан” гэж, Батсайхан овогтой Сүрэнд холбогдох хэсгийн “IGlobal University, Бизнесийн удирдлага” гэснийг “Австрали, Queensland University of Technology, хүний нөөцийн менежмент” гэж тус тус өөрчилсүгэй.
- Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /М.Мөнхбаатар/ нарт тус тус даалгасугай



САЙД

Ж.БАТСУУРЬ